

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Экспортыг дэмжих төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/25/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг</p> <p>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам</p> <p>Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин</p> <p>Утас: 261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон аудит ХХК Захирал: Б.Осоргарав</p> <p>Утас: 70110744 Цахим хаяг: osorgarav.b@mn.gt.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/364
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Экспортыг дэмжих төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Экспортыг дэмжих төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар Бараа нийлүүлэх гэрээгээр тайлант онд дуусгавар болсон 1 гэрээт ажлын 710,480.8 мянган төгрөгийн 3,862 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй, тус гэрээний үлдэгдэл төлбөр болох 2,875,808.4 мянган төгрөгт тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг илэрсэн залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 425,402.3 мянган төгрөгөөр давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын 9.4.6, 10.3-т заасантай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд уул, уурхайн бус салбарын бүтээгдэхүүнээ зээлээр экспортод гаргах боломж судалгаа шинжилгээний ажил хийж, 9 аж ахуй нэгжээс даатгалын хүсэлт хүлээн авч, андеррайтинг хийсэн, Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ хэрэгжсэн бөгөөд Mongolian exporters цахим каталогийг шинэчлэн цахим хэлбэрт шилжүүлж www.trademongolia.mn-д байршуулж, тус цахим хуудсыг англи хэлэнд хөрвүүлсэн, гадаад

худалдаа, экспортын чадавх бэхжүүлэх, уул уурхайн бус аж ахуй нэгжүүдэд гадаад экспортын чадавхыг нэмэгдүүлэх сургалт, түншлэлийн хөтөлбөрийн үнэлгээ, экспортын дэмжих төслөөс төслийн үр шим хүртэгч, хамтран ажиллагч болон бусад оролцогч талуудын хүрээнд зохион байгуулж буй “Уул уурхайн бус салбарын экспортын үйл ажиллагаанд оролцогчдын туршлага солилцох арга хэмжээ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвийн төв лабораторийг арьс шир, ноос ноолуур, гоо сайхны бүтээгдэхүүн, түүхий эдийн шинжилгээ хийхэд шаардлагатай өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжөөр хангах гэх мэт томоохон төсөл арга хэмжээний ажил хийсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын 2016 оны 8 дугаар сарын 26-ний өдрийн 5879 MN дугаартай 20,000,000 ам.долларын санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-наар дуусахаар байсан хэдий ч 2020-2021 онуудад үүссэн Ковидын нөхцөл байдал, Төслийн үндсэн зорилгын гүйцэтгэл зэргээс хамааран 2023 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл сунгасан байна.

Төслийн хаалтын хугацаа тайлант онд багтаж дуусгавар болох байсан хэдий ч томоохон хөрөнгө оруулалт бүхий бараа нийлүүлэх гэрээ тайлант хугацаандаа багтаж дуусаагүйн улмаас төслийн хаалтын хугацаа удааширч гэрээний үүргийн биелэлт хэрэгжихгүй байх эрсдэлтэй гэж үзсэн тул аудитын гол асуудалд оруулж, Төслийн удирдах хороо, хэрэгжүүлэгч Хүнс Хөдөө Аж Ахуй Яамны анхаарлыг хандуулах нь зүйтэй гэж үзэв.

Бусад асуудлын хэсэг

Экспортыг дэмжих төсөл нь Дэлхийн банкнаас баталж гаргасан “Санхүүгийн удирдах гарын авлага”-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг Дэлхийн банкинд хүргүүлдэг бол Төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Засгийн Газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн Газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягтууд, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”, УСНББОС 1-ийн дагуу аккруэл сууриар илэрхийлэн бэлтгэн хүргүүлдэг байна.

Төслийн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс төслийг бие даасан зорилт бүхий дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон зохион байгуулж Үндэсний давхар даатгал хувьцаат компани болон Төсөл хэрэгжүүлэх нэгж хэрэгжүүлнэ. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар хангах гол байгууллага нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,980,634,257.69	3,420,624,081.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,980,634,257.69	3,420,624,081.27
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	7,292,162.00
31110	Төгрөг	-	7,292,162.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,980,634,257.69	3,413,331,919.27
31210	Төгрөг	838,322,536.94	814,434,775.71
31211	Төрийн сангийн харилцах	838,322,536.94	814,434,775.71
31220	Гадаад валют	2,142,311,720.75	2,598,897,143.56
31221	Төрийн сангийн харилцах	2,142,311,720.75	2,598,897,143.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	49,436,298.71	25,179,636.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,436,298.71	25,179,636.52
39200	Биет хөрөнгө	46,123,898.71	25,179,636.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,997,825.00	92,997,825.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(69,434,345.22)	(83,712,816.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,759,141.75	28,761,861.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,198,722.82)	(12,867,233.56)
39300	Биет бус хөрөнгө	3,312,400.00	-
39301	Програм хангамж	7,644,000.00	7,644,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,331,600.00)	(7,644,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,030,070,556.40	3,445,803,717.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,020,169,052.51
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,020,169,052.51
413	Өглөг	-	4,020,169,052.51
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	753,231,448.19
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	3,266,937,604.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,030,070,556.40	(574,365,334.72)
51	Засгийн газрын хувь оролцоо	3,030,070,556.40	(574,365,334.72)
51200	Хуримтлагдсан үр дүн	3,030,070,556.40	(574,365,334.72)
51210	Өмнөх үеийн үр дүн	3,030,070,556.40	3,030,070,556.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,604,435,891.12)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,030,070,556.40	3,445,803,717.79

Экспортыг дэмжих төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,395,408,830.34	20,799,937,275.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,395,408,830.34	20,799,937,275.23
120	Нийтлэг татварын бус орлого	7,395,408,830.34	20,799,937,275.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,395,408,830.34	20,799,937,275.23
1200042	Бусад орлого	-	1,053,367.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,395,408,830.34	20,798,883,908.23
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,087,958,423.33	19,793,016,876.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,087,958,423.33	19,793,016,876.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,087,958,423.33	19,793,016,876.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,209,972.24	243,719,858.53
210101	Үндсэн цалин	193,209,972.24	243,719,858.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд өлөх шимтгэл	24,151,246.56	30,452,471.11
210201	Тэтгэврийн даатгал	17,754,538.52	20,717,070.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,642.86	2,433,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,879,000.00	1,947,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,188,065.18	4,867,701.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	486,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,095,000.00	52,500,000.00
210304	Байрны түрээс	49,095,000.00	52,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,993,664.60	15,583,381.24
210401	Бичиг хэрэг	2,741,768.27	3,672,836.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,251,896.33	11,910,544.41
2107	Томилолт, зочны зардал	824,600.00	590,000.00
210702	Дотоод албан томилолт	824,600.00	590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,785,195,508.26	19,429,704,107.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,785,195,508.26	19,429,704,107.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,488,431.67	20,467,058.19
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,488,431.67	20,467,058.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	307,450,407.01	1,006,920,399.16
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	255,395,422.56	41,436,938.71
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	255,395,422.56	41,436,938.71
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,652,793,229.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	3,789,604.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,649,003,625.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	562,845,829.57	(3,604,435,891.12)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,467,224,726.83	2,467,224,726.83
Тайлант үеийн үр дүн	-	-	562,845,829.57	562,845,829.57
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,030,070,556.40	3,030,070,556.40
Тайлант үеийн үр дүн	-	-	(3,604,435,891.12)	(3,604,435,891.12)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(574,365,334.72)	(574,365,334.72)

Экспортыг дэмжих төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,395,408,830.34	20,798,902,177.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,395,408,830.34	20,798,902,177.43
120	Нийтлэг татварын бус орлого	7,395,408,830.34	20,798,902,177.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,395,408,830.34	20,798,902,177.43
1200042	Бусад орлого	-	1,053,367.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,395,408,830.34	20,797,848,810.43
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,066,469,991.66	18,983,728,548.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,066,469,991.66	18,983,728,548.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,066,469,991.66	18,983,728,548.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,209,972.24	243,719,858.53
210101	Үндсэн цалин	193,209,972.24	243,719,858.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,151,246.56	30,452,471.11
210201	Тэтгэврийн даатгал	17,754,538.52	20,717,070.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,642.86	2,433,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,879,000.00	1,947,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	486,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,188,065.18	4,867,701.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,095,000.00	52,500,000.00
210304	Байрны түрээс	49,095,000.00	52,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,993,664.60	15,583,381.24
210401	Бичиг хэрэг	2,741,768.27	3,672,836.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,251,896.33	11,910,544.41
2107	Томилолт, зочны зардал	824,600.00	590,000.00
210702	Дотоод албан томилолт	824,600.00	590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,785,195,508.26	18,640,882,837.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,785,195,508.26	18,640,882,837.33
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	328,938,838.68	1,815,173,629.22
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,385,710,420.13
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,385,710,420.13
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,385,710,420.13
222001	Тоног төхөөрөмж	-	1,385,710,420.13
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(1,385,710,420.13)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	255,395,422.56	10,526,614.49
14	Бусад эх үүсвэр	255,395,422.56	10,526,614.49
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	255,395,422.56	10,526,614.49
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	584,334,261.24	439,989,823.58
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,396,299,996.45	2,980,634,257.69
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,980,634,257.69	3,420,624,081.27

Экспортыг дэмжих төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,426,895,800.0	20,358,912,253.85	67,983,546.15	100
УРСГАЛ ЗАРДАЛ	19,015,695,800.0	18,983,728,448.2	31,967,351.8	100
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,015,695,800.0	18,983,728,448.21	31,967,351.8	100
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,783,000.0	243,719,858.53	63,141.5	100
Үндсэн цалин	243,783,000.0	243,719,858.53	63,141.5	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,473,000.0	30,452,471.11	20,528.89	99.9
Тэтгэврийн даатгал	20,737,500.00	20,717,070.11	20,429.89	99.9
Тэтгэмжийн даатгал	2,433,800.00	2,433,800.00	-	100
ҮОМШӨ-ний даатгал	1,947,100.00	1,947,100.00	-	100
Ажилгүйдлийн даатгал	486,800.00	486,800.00	-	100
Эрүүл мэндийн даатгал	4,867,800.00	4,867,701.00	99.00	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,500,000.0	52,500,000.00	-	100
Байрны түрээс	52,500,000.0	52,500,000.00	-	100
Хангамж, бараа материалын зардал	17,371,500.0	15,583,381.24	1,788,118.8	90
Бичиг хэрэг	4,275,700.0	3,672,836.83	602,863.2	86
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,095,800.0	11,910,544.41	1,185,255.6	91
Томилолт, зочны зардал	1,000,000.0	590,000.00	410,000.0	59
Дотоод албан томилолт	1,000,000.0	590,000.00	29,685,562.7	100
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,670,568,300.00	18,640,882,737.33	29,685,562.7	100
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,670,568,300.0	18,640,882,737.33	29,685,562.7	100
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,411,200,000.0	1,375,183,805.64	25,489,579.9	98
Дотоод эх үүсвэрээр	1,411,200,000.0	1,385,710,420.13	25,489,579.9	98
Тоног төхөөрөмж	1,411,200,000.0	1,385,710,420.13	25,489,579.9	98
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,426,895,800.0	20,798,902,177.43	(372,006,377.4)	102
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,426,895,800.0	20,798,902,177.43	(372,006,377.4)	102
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	20,426,895,800.0	20,798,902,177.43	(370,953,010.4)	102
Бусад орлого		1,053,367.00	(1,053,367.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,980,634,257.70	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,420,624,181.28	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт валют	-	10,526,614.49	(10,526,614.49)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	16	16	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	5	5	-	100
Үйлчлэх ажилтан	-	-	-	-
Гэрээт ажилтан	10	10	-	100

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар 4,680.0 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аудитаар дансны өглөг, валютын ханшийн олз гарз, үндсэн хөрөнгийн шилжүүлэг зэрэг данстай холбоотой 4,679,913.9 мянган төгрөгийн дансны бичилтийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй алдааг залрууллаа.	1	4,679,913.9	-	-	-	-	1	4,679,913.9	-	-	-	-
Дүн	1	4,679,913.9					1	4,679,913.9	-	-	-	-

Экспортыг дэмжих төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитаар 710.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 710.5 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төслийн хэрэгжих хугацаа дууссан бөгөөд төсөл хэрэгжүүлэх нэгжийн балансад бүртгэлтэй үндсэн хөрөнгийг шилжүүлэх асуудлыг зохих байгууллагаар шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-				
Төслийн удирдах хороогоор батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 13,914,400.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээний ажил төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй байна.	1	-			1	-						
Бараа нийлүүлэх гэрээгээр дуусгавар болсон 1 гэрээт ажил нь 710,480.8 мянган төгрөгийн 3,862 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй, гэрээний үлдэгдэл төлбөр болох 2,875,808.4 мянган төгрөгт тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	710,480.8			1	710,480.8						
Дүн	3	710,480.8			2	710,480.8	1	-				